

**“УЛААНБААТАР ХОТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ 3R (REDUCE, REUSE, RECYCLE) ДАДАЛ БУЮУ 3R4UB” ТӨСЛИЙН ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ТЕЛЕВИЗ, РАДИОГИЙН НЭВТРҮҮЛЭГ БЭЛТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

**Төслийн нэр:** “Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төсөл

**Лавлах дугаар:** 5.8.18

**Хугацаа:** 2023 оны 11-р сарын 30-наас 2023 оны 12-р сарын 15

**Төсөв:** 15.000.000 төгрөг

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

“Switch Asia” хөтөлбөрийн хүрээнд Европын холбооноос санхүүжүүлж буй “Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төслийг Италийн үндэсний судалгааны зөвлөлөөр ахлуулан Монгол-Италийн түнш байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. БОАЖЯ-ны харьяа “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ нь уг төслийн мэдээлэл харилцаа болон нөлөөллийн хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлдэг болно.

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ нь байгаль орчин, экологийн боловсрол олгох чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг цөөн тооны байгууллагуудын нэг бөгөөд тэр дундаа бага насны хүүхэд, сурагчид, оюутнууд зэрэг зорилтот бүлгийн нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн байгаль орчин, экологийн боловсрол олгох албан бус боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн өмчит цорын ганц байгууллага билээ.

**ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО**

“Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төслийг олон нийтэд сурталчлан таниулах, бүх нийтэд хог хаягдлын менежментийн 3R (reduce, reuse, recycle) зарчмыг ойлгуулах, тэдний мэдлэг, хандлагад нөлөөлөх замаар 3R дадлыг төлөвшүүлэх хүрээнд сургалт, танин мэдэхүйн телевиз радиогийн нэвтрүүлэг бэлтгэн түгээх зорилготой

**ГУРАВ. АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

**3.1.1 Нэвтрүүлэг бэлтгэх байгууллага дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:**

<b>Ажил үүргийн агуулга</b>	<b>Шалгуур үзүүлэлт хэмжүүр</b>
Зохиол	Захиалагчийн өгсөн ерөнхий санаанд үндэслэн нэвтрүүлгийн зохиол боловсруулан танилцуулж, батлуулах
Санал авах	Нэвтрүүлгийн батлагдсан зохиолын дагуу бичлэгийн титер бэлтгэн танилцуулж, титер дээр захиалагчаас санал авах
Танилцуулах	Нэвтрүүлгийг бэлтгэн захиалагчид танилцуулж, захиалагчийн саналыг тусгаж засвар оруулна.

Эцсийн бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>• Өргөн нэвтрүүлгийн сувгаар цацах нэвтрүүлэг 15-20 минутын 1ш /Англи хадмал, дохионы хэлний орчуулгатай/</li> <li>• Хураангуй видео /Promo/ 2-4 минутын 1ш</li> <li>• Богино контент /Reels/ 5 хүртэлх минут 2-3ш</li> <li>• FM, Радиод зориулсан аудио нэвтрүүлэг 10-15 мин 1ш</li> </ul>
---------------------	--

### 3.1.2 Нэвтрүүлэгт тавигдах шаардлагууд

- Нийт 15-20 минут хугацаатай видео нэвтрүүлэг байх;
- Видеоны ажлыг санал хүсэлтийн үндсэн дээр нэмэлт төлбөргүйгээр засвар оруулж өгөх;
- Видеоны ажлуудад ашигласан зүйлс нь бусдын оюуны өмчийг хууль бусаар ашиглаагүй байх;
- Элдэв дуу шуум орохгүй, стандартад нийцсэн микрофон ашиглаж, цэвэрхэн дуугаралттай байх;
- Дүрсний өндөр чанартай, нягтаршил сайтай, өргөн нэвтрүүлгээр нэвтрүүлэх стандарт, шаардлагад нийцсэн байх ;
- Гэрэлтүүлэг, бичлэгийн орчин сайн байх ;
- Видеог дохионы хэлний орчуулгатайгаар хүлээлгэн өгөх;
- Шинжлэх ухааны үндэслэлтэй агуулга, мэдээлэл оруулах, эх сурвалжийг дурьдах;
- 3D, 2D creative/ бүтээлч хэв маягтай байх.

### 3.1.3 Гүйцэтгэгч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Нэр	Тодорхойлолт
Хуулийн этгээд байх	Үйл ажиллагааны чиглэл гүйцэтгэх ажлын чиглэлтэй нийцсэн байх;
Ажлын туршлага	Ижил төрлийн бичлэг, нэвтрүүлэг гүйцэтгэж байсан ажлын туршлагатай байх;
Баталгаа	Дээрх шаардлагуудыг хангасан талаар нотлох баримт, баталгааг ирүүлэх

### ДӨРӨВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

- Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаагаар ажил эхэлж, гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгч ажил гүйцэтгэсэн акт гүйцэтгэж өгснөөр ажил дуусгавар болно.
- Ажил гүйцэтгэгчийн ажлын явц, гүйцэтгэлд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн “3R4UB төсөл” - ийн ажлын хэсгийн ахлагч болон холбогдох ажлын хэсгийн гишүүд байнгын хяналт тавьж ажиллана.
- Ажил гүйцэтгэгч нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн холбогдох ажилтнуудтай байнгын холбоотой ажиллана.

## **ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ БА ӨМЧЛӨЛ**

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн зүгээс өгсөн мэдээ, мэдээллийг баталгаажсан албан бичиг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Гүйцэтгэх ажлын хүрээнд боловсруулсан видео бичлэг, бэлтгэсэн нэвтрүүлэг нь захиалагч талын өмч байна.

## **ЗУРГАА. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- Ажил гүйцэтгэх хугацаа болон төлбөрийн нөхцөлийг ажил гүйцэтгэх гэрээгээр тогтоно.

## **ДОЛОО. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

- Байгууллагын танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Ижил төстэй хийж байсан видеоны ажлууд (салангид файлаар илгээх эсвэл үзэх боломжтой линкийг илгээсэн байх);

## **НАЙМ. ХОЛБОО БАРИХ**

Сонирхсон байгууллагууд Монгол хэлээр бэлтгэсэн материалаа 2023 оны 12-р сарын 4-ний өдрийн 10:00 цагаас өмнө дор дурдсан цахим шуудангаар ирүүлнэ үү.

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ

Хан-уул дүүрэг 11-р хороо, Зайсангийн гудамж -9

Цахим хаяг: [tsengegusnuuts@gmail.com](mailto:tsengegusnuuts@gmail.com)

Утас: 70107643 / Ажлын цагаар /